

1990-ЭЭД ОНЫ МОНГОЛ УЛС, БНАСАУ-ЫН ХАРИЛЦАА: БНАСАУ МОНГОЛ ДАХЬ ЭСЯ-АА ХААСАН НЬ ХОЁР ОРНЫ ГАДААД БОДЛОГЫН ОНЦЛОГ

*С.Батсайхан**

Abstract: From 1990 in a rooty the foreign policy of Mongolia changed, Mongolia not only maintained diplomatic relations with North Korea (NK) but also established diplomatic relations with South Korea. Mongolia in the Concepts of Foreign Policy defined South Korea is the third neighbor, but declared the balanced relation. And North Korea unfriendly accepted on it. In 1999, during the visit of the President of South Korea Kim Dae Jung in Mongolia, North Korea with a claim that Mongolia supported Kim Dae Jung to the politician of "involvement", closed the embassy in Mongolia. But reason of this incident of NK was in other, the main reason was economic difficulty of the country.

Key words: Features of Mongolia-North Korean relations of the 1990th: North Korea closed Embassy in Mongolia.

* * *

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улсын гадаад бодлого үндсээрээ өөрчлөгдсөн юм. Монгол улс Үндсэн хуулиндаа (1992): “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”² гэж гадаад бодлогоо тодорхойлсон ба Гадаад бодлогын үзэл баримтлал (ГБҮБ, 1994) батлан гаргасан нь Монгол Улсын гадаад бодлогыг илүү тодорхой болгожээ. Монгол Улсын ГБҮБ-д: “Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна”, “Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо энхийг эрхэмлэж, улс гүрэнтэй сэргөлдөхгүй байхыг аль болохоор чухалчилж, олон тулгуурт бодлого явуулна. Үндэснийхээ ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт бусад улс, түншийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ” гэж заажээ.³ Мөн гадаад бодлогынхоо зорилтыг: “Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн” хэмээн тодорхойлсон юм.⁴ Мөн гадаад бодлогынхоо чиглэлд ЗХА болон хоёр Солонгостой харилцах талаар тусгахдаа, тус гадаад бодлогын үзэл баримтлалын (1994) II.12.2,3,5-т:

* МУИС-ийн ОУХНУС-ийн докторант

² МУ-ын Үндсэн Хууль, 1992 I.10.1 (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №1(7). 1992.1.2-р сар. Тал.3)

³ МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал 1994. I.3., II.9. (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9(28). 1994.09.01. Тал.805-807)

⁴ МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал 1994. I.2. (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9(28). 1994.09.01. Тал.806)

2/ Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Үүний хамт Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани, Нидерланд, Финланд, Австри, Швед, Швейцарь зэрэг оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтална;

3/ Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн Хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарна. Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын аюулгүй байдлын механизм буй болгох үйл явцад идэвхтэй оролцоно...

4/ социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнууд, шинээр тусгаар тогтносон улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын дөрөв дэх чиглэл байна. Эдгээр улстай харилцахдаа өмнөх харилцааны нааштай өвийг багатгахыг чухалчлахын хамт харилцаагаа шинэ нөхцөлд зохицуулан хөгжүүлэх бодит боломжийг харгалзан уян хатан хандана... гэж заажээ.⁵

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд: социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнууд, шинээр тусгаар тогтносон улсуудтай найрсаг харилцаагаа шинэ нөхцөлд зохицуулан хөгжүүлэх, Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын аюулгүй байдлын механизм буй болгох үйл явцад идэвхтэй оролцоно гэсэн заалтууд нь БНАСАУ-тай харилцах харилцаанд тусгалаа олсон. Монгол Улс найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр БНАСАУ-тай харилцахын хамт тус улстай шинэ нөхцөл байдалд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг чармайж байв. ЗХА-д аюулгүй байдлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Монгол нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарлаж, БНАСАУ-ын цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг буруушааж, 6 талт хэлэлцээг амжилттай явуулахад тус дөхөм үзүүлж ирсэн.

Харин БНАСАУ-ын хувьд Гадаад бодлогын үзэл баримтлал гэсэн баримт бичиг гаргаагүй, гагцхүү Үндсэн хууль болон СХН-ын их, бүгд хурлуудын баримт бичиг, тус хурал дээр удирдагч Ким Ир Сен, Ким Жон Ир-ийн хэлсэн үгнээс гадаад бодлогынх нь ерөнхий чиглэл тодорхойлогддог онцлогтой юм. 1980 оны 10-р сард хуралдсан СХН-ын 6-р их хурлаас гадаад бодлогынхоо үндсэн үзэл баримтлалыг бие даасан байдал, найрамдал, энх тайван гэсэн 3 зарчмаар тодорхойлжээ. Тухайлбал: “Гадаад үйл ажиллагаандаа бие даасан байдлыг баттай баримталж, дэлхийн олон улстай энх тайванч хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлж, дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахын төлөө чармайн ажиллах болно. Бие даасан байдал, найрамдал, энх тайван эдгээр нь манай намын гадаад

⁵ МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал 1994. II.12.2,3,5 (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9(28). 1994.09.01. Тал.807, 808)

бодлогын үндсэн үзэл баримтлал” юм гэжээ.⁶

БНАСАУ-ын Үндсэн хуулийн (1992) 1.17-д: “БНАСАУ-ын гадаад бодлогын үндсэн үзэл санаа ба гадаад үйл ажиллагааны зарчим нь бие даасан байдал, энх тайван, найрамдал юм. Улс бүрэн эрх тэгш байдал ба бие даасан байдал, харилцан хүндэтгэл ба дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх, харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурлан манай улстай нөхөрсөг харилцаатай бүх улстай улс төр, эдийн засаг, соёлын харилцаа тогтооно. Улс бие даасан байдлаа хамгаалах гэсэн бүх улстай нэгдэн нийлж, бүх төрлийн түрэмгийлэл ба бусад улсын дотоод асуудалд оролцохын эсрэг, тусгаар тогтнол, үндэстний болон ангийн чөлөөллийн төлөөх бүх улс орны тэмцлийг идэвхтэй дэмжинэ” гэж тунхаглажээ.⁷ (БНАСАУ-ын Үндсэн хууль. 1992. I.17) Эдгээр заалтыг тус улсын гадаад бодлогын үндсэн үзэл баримтлал гэж үзэж болох бол харин гадаад бодлогынх нь чиглэл хаалттай тул гагцхүү үйл явцын өрнөлтөөс л тодорхойлох боломжтой гэж үзнэ. Мөн социалист улсын хувьд гадаад бодлого нь “дотоод бодлоготойгоо нягт холбоотой тул дотоод бодлогын үргэлжлэл” гэж үзэж болох талтай.⁸

БНАСАУ-ын гадаад харилцаа

БНАСАУ 1948 онд ЗХУ, 1950 онд БНХАУ-тай гэх мэтээр 1960 он хүртэл социалист системийн 16 улстай дипломат харилцаа тогтоож, харин АНУ тэргүүтэй барууны улс орнуудыг империалист дайсагнагч улс гэж тодорхойлж, ямар нэгэн харилцаагүй явж иржээ. 1960-аад оноос БНАСАУ, БНСУ-тай өрсөлдөж аль болох олон улс оронтой дипломат харилцаа тогтоох нэн идэвхтэй гадаад бодлого явуулах болсон юм. Тус улс империализм колончлолын эсрэг уриан дор Ази, Африк, Латин Америкийн дэлхийн 3-дагч орнуудын тусгаар тогтнолыг дэмжиж, шинээр тогтсон улсуудтай идэвхтэй дипломат харилцаа тогтоох болсноор 1980 он гэхэд 100 гаруй улстай дипломат харилцаатай болжээ. 1971 онд АНУ-ын Ерөнхийлөгч Р.Никсон БНХАУ-д айлчилж, Азид түүний дотор Өмнөд Солонгост цэргийн оролцоогоо бууруулна гэж мэдэгдсэний дараа АНУ-тай ч харилцаа тогтоох оролдлого хийж байв. 1973 онд Дани, Финлянд, Исланд, Норвеги, 1974 онд Австри, Швейцарь, 1975 онд Португал зэрэг Европын дундыг сахисан улсуудтай дипломат харилцаа тогтоожээ. 1990 он гарсаар ЗХУ задарсны дараа шинээр тусгаар тогтносон Хамтын нөхөрлөлийн орнууд ба Европ тивд Македони, Гүрж, Босни Герцоговин, Африк тивд Өмнөд Африкийн БНУ, Зүүн Өмнөд Азийн Бруней зэрэг улсуудтай дипломат харилцаа тогтоожээ. 2000 оноос Францаас бусад ЕХ-ны 8 улс, мөн Австрали, Филиппин, Турк, Канад, Бразил, Шинэ Зеланд, Кувейт, Лихтенштейн зэрэг улсуудтай дипломат харилцаа тогтоосон ба зарим оронд Элчин сайдын яамаа шинээр нээжээ. Тухайлбал: 2000 онд Хонконгод төлөөлөгчийн газар, Италид Элчин сайдын яам, 2001 онд Германд, 2002 онд Австрали ба Өмнөд Африкийн БНУ-д, 2003 онд Англид Элчин сайдын яамаа нээжээ. Харин 1990-ээд оны дундуур, эдийн

⁶ 조선중앙년감.(Чосон төв товхимол) 1981, pp. 66-67

⁷ БНАСАУ-ын Үндсэн хууль 1992. I.17

⁸ 한국정치연구회, “북한정치론”. 서울백산서당, (Солонгосын улс төрийн шинжлэлийн хүрээлэн, “Умард Солонгосын улс төрийн онол”. Сүүл: Бэк Сан Со Дан)1990, p.400

засгийн хүндрэл, бусад шалтгааны улмаас Ямайк, Бенин, Португал, Никарагуа, Тунис, Борокино-Пасо, Камерун, Лебон, Конго, Бурунди, Мозамбик, Унгар, Монгол зэрэг 13 улсад Элчин сайдын яамаа хааж байв. 1998 оны 3-р сард Элчин сайдын яамаа 30% хорогдуулсан гэсэн мэдээ бий.⁹

**БНАСАУ-ын Дипломат төлөөлөгчийн газар
(2010 оны 12 сарын байдлаар)**

Тив	Дипломат төлөөлөгчийн газар	Ангилал	Тоо
Ази	16	Элчин сайдын яам Консулын газар	14 2
Америк	5	Элчин сайдын яам Консулын газар Төлөөлөгчийн газар	4 0 1
Европ	16	Элчин сайдын яам Консулын газар Төлөөлөгчийн газар	12 1 3
Дундад Ази	5	Элчин сайдын яам Консулын газар Төлөөлөгчийн газар	5 0 0
Африк	7	Элчин сайдын яам	7
Нийт	49		

(통계청, “북한의 주요통계지표”. 2011년.p.123.)

БНАСАУ одоогийн байдлаар 160 улстай дипломат харилцаатай ба харин дэлхий болон бүс нутгийн нөлөө бүхий АНУ, Япон г.м. улстай өнөөг хүртэл дипломат харилцаагүй явж ирэв. Хүйтэн дайн дуусгавар болох үеэс (1990) Умард Солонгос нь АНУ ба Япон улстай харилцаагаа нээлттэй болгох, ялангуяа Японтой хэвийн харилцаатай болохыг эрэлхийлж байсан ч тус улсын дэглэмээ хадгалж үлдэх гэсэн хэт хаалттай бодлого энэ бүхэнд саад болсон юм. 6 талт хэлэлцээний хүрээнд Умард Солонгос тус хоёр улстай харилцаагаа хэвийн болгох асуудал тавигдсан ч хэлэлцээ зогссоноор энэ асуудал мөн л хойшлогджээ.

Монгол Улсын хоёр Солонгосын талаар баримтлах бодлого

Монгол, БНАСАУ-тай 1948 онд буюу тус улстай дипломат харилцаа тогтоосон хоёр дахь улс болсон нь хоёр орны харилцааны нэг онцлог ажээ. 1950 оны хавар БНМАУ-ын Элчин сайдын яам Пёнъян хотноо байгуулагджээ. Хүйтэн дайны төгсгөл хүртэл Монгол зөвхөн Умард Солонгостой дипломат харилцаатай байсан бол 1990 онд Өмнөд Солонгос буюу БНСУ-тай дипломат харилцаа тогтоосон. Монгол, БНАСАУ-ын харилцаанд Монгол харилцаагаа хэвийн хадгалах, шинэ нөхцөл байдалд харилцан ашигтай хамтран ажиллана гэсэн зарчим баримталсан бол харин Монгол, БНСУ-ын хооронд “харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл”(1999), “сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл”

⁹ 김계동,북한의 외교정책과 대외관계 (Ким Гие Дун. Умард Солонгосын гадаад бодлого ба гадаад харилцаа) 2012. p. 79

(2006) гэсэн зарчмаар харилцаа хөгжиж ирэв.¹⁰ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд (1994), “Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Үүний хамт Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани, Нидерланд, Финланд, Австри зэрэг оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтална” гэж заасны дагуу Монгол, БНСУ-тай түлхүү харилцах болжээ. 1990-ээд оны дунд үеэс Монгол, БНСУ-ын харилцаа эрчимтэй хөгжсөн бол Монгол, БНАСАУ-ын харилцаа 1999 онд Умард Солонгос Монголоос Элчин сайдын яамаа татах хүртэл нэлээд муудсан тал бий. Энэ нь Монгол-БНАСАУ, Монгол-БНСУ-ын эдийн засгийн харилцааны ерөнхий дүр зургаас тодорхой харагдана. Тухайлбал 1991-1996 оны хооронд Монгол, БНАСАУ-ын гадаад худалдааны нийт хэмжээ ойролцоогоор 2,3 сая доллараас тасралтгүй буурч 131,6 мянган ам. долларт хүрч энэ хэмжээндээ хадгалагдсан бол эсрэгээрээ Монгол ба БНСУ-ын гадаад худалдааны нийт хэмжээ ойролцоогоор 5,7 сая ам.доллараас тасралтгүй өссөөр 28 сая ам.долларт хүрч, мөн өнөөг хүртэл тасралтгүй өссөөр 2008 онд 269 сая ам.долларт хүрчээ. Монгол ба БНАСАУ-ын эдийн засгийн харилцаа ийнхүү буурсан шалтгаан нь хоёр улсад социалист систем нуран унахад үүссэн эдийн засгийн хүндрэлтэй шууд холбоотой. Социалист улсууд, ЗХУ-ын зээл тусламж бүрэн зогссоноор Монгол Улс үзэл суртал гэхээсээ эдийн засгийн харилцан ашигтай харилцааг чухалчилж байв. Ер нь капиталист эдийн засаг түүхий эд материал, зах зээл, хөрөнгө оруулалтын боломжийг гаднаас хүчтэй хайдаг онцлогтойн хувьд эдийн засаг гадаад бодлогод хүчтэй нөлөөтэй гэж үздэг.¹¹ Энэ ч утгаараа Монгол, БНСУ-ын харилцаа илүү хурдтай хөгжсөн гэж дүгнэж үзэх бүрэн үндэстэй. Ийнхүү хоёр оронд гарсан эдийн засгийн хүндрэл харилцаанд ч мөн тусгалаа олсон ажээ.

Ким Дэ Жүн-ий “нарны элч”-ийн бодлого

Монгол, БНСУ-ын харилцаа зөвхөн эдийн засгийн салбарт ч бус улс төрийн салбарт ч идэвхтэй өрнөсөн юм. 1991 онд МУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Дэ У-гийн урилгаар тус улсад төрийн айлчлал хийсэн бол 1999 оны 5 сард БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн Монголд түүхэн айлчлал хийжээ. Энэхүү айлчлал Монгол, БНАСАУ-ын харилцаанд өөрчлөлт авчирсан айлчлалт байсан юм. Ким Дэ Жүн нь ардчиллыг тууштай тэмцэгч, нобелийн шагналт, улс төрийн нэрт зүтгэлтэн ба 1998 онд БНСУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Түүний улс төрийн гол бодлого нь хоёр Солонгосыг эвлэрүүлэх, цаашид нэгтгэхэд чиглэгдсэн. Ким Дэ Жүн БНСУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсоныхоо дараа БНАСАУ-ын хувьд үр ашигтай гэмээр программ болох “нарны элчийн” буюу “татан оролцуулах” бодлогыг дэвшүүлсэн юм. Өөрөөр хэлбэл энэ нь Умард Солонгосыг дэлхийн хамтын нийгэмлэгт “татан оролцуулах” бодлого байсан. Тэрбээр “нарны

¹⁰ Д.Уламбаяр. БНСУ-МУ-ын “гуравдагч сайн хөрш,” чухаг түнш мөн. Монгол Солонгосын харилцаа хамтын ажиллганы тулгамдсан асуудал хэтийн төлөв. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. 2010

¹¹ John Lewis Gaddis, “The Long Peace: Elements of Stability in the Postwar International System,” in Sean M, Lynn-Jones, ed. The Cold War and After: Prospects for Peace,(Cambridge, Massachusetts: The MIT Press,1991), p.17

элч”-ийн бодлогоо явуулахдаа 4 зарчимд тулгуурлана гэж томъёолжээ. Нэгдүгээрт: БНСУ Умард Солонгосыг уусгахыг санаархахгүй, Хоёрдугаарт: БНСУ, БНАСАУ-тай бүх талаар эвлэрэх ба хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих, Гуравдугаарт: БНСУ, БНАСАУ-ын цэргийн өдөөн хатгалгад нэн даруй, тохирохуйц хариу барих, Дөрөвдүгээрт: БНСУ улс төрийг эдийн засгаас салгаж үзэх ба яриа хэлэлцээрийг оршин буй асуудлыг зохицуулах хэрэгсэл гэж үзнэ гэсэн зарчмыг дэвшүүлсэн.¹²

Харин БНАСАУ-ын тал Ким Дэ Жүний дэвшүүлсэн “нарны элч”-ийн бодлогыг “Умард Солонгосын социализмыг устгах, БНАСАУ-ыг багалзуурдаж сөнөөх” оролдлого гэж үзэж, сөргөөр хүлээн авсан юм. БНАСАУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр: “Өмнөд Чосоны эрх баригчдын тулгаж буй “нарны элч”-ийн бодлого нь БНСУ-ыг нээлттэй бодлогод татан оролцуулж улс төрийн үзэл санааны зэвсгийг устгаж социалист хувцсаа тайлж хаях гэснээрээ нэгдэх зарчмыг зөрчсөн БНСУ-ын эсрэг, нэгдлийн эсрэг сөргөлдүүлсэн мэдэгдэл” юм. “Нарны элч”-ийн бодлогын үндэс нь гадны хүч ба бүлэглэл, Умард Солонгосын үзэл санаа ба системийг боогдуулснаар Өмнөд Чосоны талаарх Америкийн колончлолын дэглэмийг манай БНСУ хүртэл үргэлжлүүлэх гэсэн мэдэгдэл юм”. “Империалист улсууд өөрчлөлт, нээлттэй бодлогод татан оролцуулахаар эрээ цээргүй өдөөн хатгаж байгаа тул бие даасан зарчмаа эцсээ хүртэл хамгаална”. “Өмнөд Чосоны эрх баригчид Умард Солонгосыг нээлттэй бодлогод татан оролцуулах хэрэгтэй хэмээн чалчиж байгаа ч цоож нь хаалганы дотор талд зүүлттэй байдаггүйчлэн америк зэрэг дэлхийн сөрөг хүчний хязгаарлалт тул бут цохимогцоо үүднээсээ арчиж хаяна” зэрэг мэдэгдлүүд явж ихээхэн шүүмжилж байв.¹³ Ийнхүү БНАСАУ “нарны элч”-ийн бодлогыг хүлээж авахаас татгалзаж, буруушаасан ч, Ким Дэ Жүн уг бодлогоосоо няцалгүй, тууштай явуулж, хоёр орны хооронд оршин буй асуудлыг Ким Жон Иртай Пёнъянд уулзаж хэлэлцэхэд бэлэн байгаагаа илэрхийлж байсны үр дүнд 2000 онд Өмнөд, Умардын дээд хэмжээний уулзалт болж, хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зуралцах үйл явдал болсон ажээ.

Ким Дэ Жүн Монголд хийсэн айлчлалын дүнд хамтарсан мэдэгдэл гаргажээ. Хамтарсан мэдэгдлийн 4-т: “Ерөнхийлөгч Ким Дэ Жүн Умард Солонгосын талаар явуулж байгаа “татан оролцуулах бодлого”, 4 талын хэлэлцээ зэрэг Солонгосын хойгт энх тайван, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн БНСУ-ын Засгийн газрын үйл ажиллагааг тайлбарлав. Ерөнхийлөгч Н.Багабанди БНСУ-ын байр суурийг бүрэн ойлгож дэмжиж байгаагаа болон энэ асуудлаар ойрын ирээдүйд тодорхой ахиц гарна гэж найдаж байгаагаа илэрхийлэв” гэж тэмдэглэжээ.¹⁴ Гэвч энэхүү мэдэгдэлд “татан оролцуулах бодлого” гэж онцлоогүй ба Монгол, БНСУ-ын байр суурийг дэмжинэ гэсэн нь өргөн угтаттай гэж үзэх бүрэн үндэстэй.

¹² Панин.А. Северная Корея. Эпоха Ким Чен Ира на закате. 2004. стр. 245

¹³ (“평양방송”(Пхеньяны радио нэвтрүүлэг) 1998년9월13일, 10월3일, 11월13일, 로동신문-근로자 공동노살”, “자립적 민족경제 건설노선 견지”, (Нодон шинмүн) 1998.9.17김계동.북한의 외교정책과 대외관계. 2012. p.205)

¹⁴ Гадаад харилцаа. Товхимол. 1999.6.4 №13. Тал.5

БНАСАУ Монгол дахь ЭСЯ-аа хаасан нь

Дээрх мэдэгдэлтэй холбогдуулан БНАСАУ-аас Монгол Улсад сууж байсан Элчин сайд Жөн Жан Ён 1999 оны 6 сарын 7-нд МУ-ын ГХЯ-ны УТГ-ын орлогч дарга Л.Даваагивт БНАСАУ-аас Монголд суугаа ЭСЯ-аа хаах болсноо мэдэгдэж, мөн дараа өдөр нь уулзахдаа: “Өмнөд Солонгосын эрх баригчдын харгис хуурмаг “нарны элч” бодлого нь манай ард түмнийг доромжилсон хэрэг юм. Энэ нь АНУ-аас хуучин ЗХУ-ыг задалж, “энх тайвнаар өөрчилнө” гэсэн харгис бодлогын Өмнөд Солонгос маягийн хувилбар юм. Тайванийг ашиглаж БНХАУ-ыг “энх тайвнаар өөрчлөх” бодлогын адил хувилбар... Монголын ЗГ нэгдлийн эсрэг чиглэсэн энэхүү бодлогыг дэмжиж, түүнд амжилт гаргахыг хүсч, хамтран ажиллахаа амласан нь Умард, Өмнөдийн харилцаанд төвийг сахина гэсэн байр сууринаасаа ухарч, Өмнөд Солонгосын бодлогыг дэмжигч болж хувирсныг харуулж байна. Энэ нь дайснуудтай сөрөн зогсч байгаа манай ЗГ-ын урмыг хугаллаа. Монголд суугаа ЭСЯ-ыг хаахыг шаардаж байна. Гарах хариуцлагыг Монголын тал хүлээх ёстой” хэмээн мэдэгджээ. Мөн өдөр нь Элчин сайд Жөн Жан Ён-ыг Монгол Улсын ГХ-ны сайд Н.Туяа хүлээн авч уулзан, “БНАСАУ ЭСЯ-аа хойшид тогтвортой ажиллуулна гэж найдаж байгаагаа илэрхийлж, энэ нь хоёр талын харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг” мэдэгдсэн байна. Үүний хариуд Элчин сайд Жөн Жан Ён: “...Өнөөг хүртэл Монгол Улс Солонгосын хойгийн нарийн төвөгтэй асуудлаар БНАСАУ болон БНСУ-ын байр суурийн аль алиныг нь дэмжсэн удаа байхгүй. Харин энэ удаа Монгол Улс “нарны элч”-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ахиц гаргахыг хүсч, энэ талаар Өмнөд Солонгостой идэвхтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн. Манай ЗГ-ын эх орноо нэгтгэх бодлогод Монголын ЗГ тийм ч хүчтэй дэмжлэг үзүүлээгүй. Үүнийг бид Монгол Өмнөд Солонгосын талд орсон, тэр тал руу хазайсан болохыг харуулж байна гэж үзэж байна” гэжээ.¹⁵ 1999 оны 6-р сарын 9-нд БНАСАУ-д сууж байсан Монгол Улсын Элчин сайд Д.Бямбаа-тай БНАСАУ-ын ГХЯ-ны Х газрын дарга Ма Чол Су уулзахдаа...” Монгол Улсын Ерөнхийлөгч Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч гэгч Ким Дэ Жүнийг халуун дотноор хүлээн авч, түүний “нарны элч” хэмээх харгис бодлогыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. “Нарны элч” бодлого гэгч нь манай БНАСАУ-ыг аажмаар уусгах, үзэл суртлын талаар нэвтрэн орж улмаар манай улсын нийгмийн байгууллыг өөрчлөхөд чиглэсэн харгис бодлого юм” гээд Элчин сайдын яамаа хаах шийдвэр гаргаснаа уламжилжээ.¹⁶ Улмаар 1999 оны 8-р сарын 25-нд БНАСАУ-ын тал ЭСЯ-аа хаах болсон тухай нот бичиг илгээжээ. Уг нот бичигт, БНАСАУ-ын ЗГ-ын шийдвэрийн дагуу тус ЭСЯ-аа хааж, БНАСАУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-наас хавсаргах болсноо албан ёсоор мэдэгджээ.¹⁷ Уг нот бичигт чухам ямар шалтгааны улмаас хааж байгаагаа дурдаагүй байна. Монгол Улс БНАСАУ Улаанбаатар дахь Элчин сайдын яамаа хааж, БНХАУ-д хариуцуулах болсонд сэтгэл дундуур үлдсэн ба ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга О.Очиржавыг 10-р сард БНАСАУ-д айлчлах үеэр уг асуудлыг хөндөхөд БНАСАУ-ын тал ЭСЯ-аа дахин нээх асуудлыг авч үзэх бололцоогүй болохыг

¹⁵ ГХЯ-ны архив. Хн:211. Тал.58-60

¹⁶ Мөн тэнд. Хн:208. Тал.6,7

¹⁷ Мөн тэнд. Хн:211. Тал.68

мэдэгдсэн байна. БНАСАУ ЭСЯ-аа хаасантай холбогдуулан Монголд ажиллаж байсан 200-аад барилгачин, иргэд нутаг буцжээ. Мөн Умард Солонгосын тал өмнөх хоёр орны ЭСЯ-ны түрээсийн хөнгөлөлттэй нөхцөлийг цуцалж, 2000 оны 1-р сарын 1-нээс эхлэн Монгол Улсын ЭСЯ-ны түрээсийн төлбөрийг Пёньян дахь гадаадын ДТГ-уудын нэгэн адилаар төлөх болсныг манай талд нот-оор мэдэгджээ. Умард Солонгосын талын дээрх мэдэгдлүүд Монгол Улс Ким Дэ Жүний “татан оролцуулах” бодлогыг дэмжсэний хариуд тус улс Улаанбаатар дахь Элчин сайдын яамаа хаажээ гэсэн ойлголтыг дэлхийн олон нийтэд төрүүлсэн юм. Гэвч зөвхөн энэ шалтгаан ЭСЯ-аа хаахад хүргэсэн гэж үзэх нь учир дутагдалтай.

БНАСАУ Монгол дахь ЭСЯ-аа хаах болсон шалтгаан

БНАСАУ Монгол дахь ЭСЯ-аа хаах асуудлыг үүнээс хоёр жилийн өмнө буюу 1997 онд мөн тавьж байсан юм. БНАСАУ-аас Монголд сууж байсан Элчин сайд Юу Ван манай орны ГХ-ны яаманд, Умард Солонгосын эдийн засгийн байдал хүнд байгаагийн улмаас хэдийгээр хоёр тал Элчин сайдын яамны байрны түрээсийн төлбөрөөс харилцан чөлөөлөгдсөн ч халаалтын мөнгө өндөр гардаг, хэмжээ нь том тул Пёньян дахь Монголын Элчин сайдын яамныхтай адил болгох, ЭСЯ-аа татан буулгах зэрэг асуудлыг тавьж, үүний хариуд Монголын тал тус улсын Элчин сайдын яамыг Энэтхэгийн элчин сайдын яамны байр луу шилжүүлж болох тухай саналаа гаргаж байв.¹⁸ Харин БНАСАУ тал 1997 оны 11 сарын 18-нд Монгол дахь ЭСЯ татан буулгах болсноо мэдэгджээ. Уг мэдэгдэлд, БНАСАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-аа харамсалтайгаар татан буулгах болсноо мэдэгдэж, энэ нь тус улсад түр зуур буй болсон цэвэр эдийн засаг, санхүүгийн байдлаас үүдэн гарснаас биш улс төрийн өөрчлөлтөөс болсон явдал биш юм гэдгийг онцлон тэмдэглэсэн юм.¹⁹ Монгол Улсын ЗГ тус орны ЭСЯ-ыг хаалгахгүй байхад хүчин чармайлт гаргаж, ГХЯ-ны ТНБД О.Очиржавыг 1997 оны 12 сард тус улсад айлчлах үеэр уг асуудлыг тавьсны үр дүнд БНАСАУ-ын ЭСЯ-аа хаах асуудлыг энэ удаад зогсоож чадсан ажээ.

Ким Дэ Жүний “татан оролцуулах” бодлогыг зөвхөн Монгол дэмжсэн бус ОХУ, БНХАУ, Вьетнам улсууд ч дэмжсэн юм. Тухайлбал: Ким Дэ Жүн 1999 оны 5-р сард ОХУ-д айлчлах үеэр гаргасан ОХУ, БНСУ-ын хамтарсан мэдэгдэлд: “Оросын тал... Ким Дэ Жүний ЗГ-ын зөвхөн Солонгосын хойгийн төдийгүй нийт бүс нутгийн энх тайвныг бэхжүүлэх, тогтворжуулахад тус дөхөм болох солонгос хоорондын харилцааг зохицуулах, Өмнөд, Умард Солонгосын үр бүтээлтэй яриа хэлэлцээрийн чиглэлийг дэмжиж байдаг”²⁰ гэж дурдсан бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Ельцин, БНСУ-ын Умард Солонгосын талаарх бодлогыг дэмжихээ илэрхийлжээ. БНХАУ-ын Ерөнхий сайд Жү Рунжи БНСУ-ын БХ-ын сайдыг 1999 оны 8-р сард хүлээн авч уулзахдаа “татан оролцуулах” бодлогыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Вьетнамын ГХ-ийн сайд Вон Мангаб БНСУ-ын Гадаад хэрэг, худалдааны сайд Хон Сун Ен тус улсад айлчлах үеэр “БНСУ-ын Умард Солонгосын талаарх “татан

¹⁸ Мөн тэнд. Хн:198. Тал.59

¹⁹ Мөн тэнд. Хн:198. Тал.66

²⁰ Г.Толорая. Корейская политика России: Попытка схематизации. Журнал “Проблема дальнего Востока” 1999.10

оролцуулах” бодлого нь Солонгосын хойгийн энх тайванд тус хүргэж байна хэмээн үнэлж байна” гэж мэдэгджээ.²¹

Энэ бүхнээс харахад БНАСАУ Монголоос ЭСЯ-аа татсан нь зөвхөн Ким Дэ Жүний “таган оролцуулах” бодлогыг дэмжсэнд биш байгаа ажээ. Харин үндсэн 2 шалтгаантай гэж дүгнэж болохоор байна. Нэгдүгээрт: 1990-ээд оноос эхэлсэн БНАСАУ-ын санхүү, эдийн засгийн хүндрэл, тус улсыг гадаад дахь хэд хэдэн элчин сайдын яамаа хаахад хүргэсэн ба үүний дотор Монгол дахь Элчин сайдын яам оржээ. Хоёрдугаарт: Монгол, БНАСАУ-ын харилцаанд гарсан өөрчлөлт буюу хоёр орны харилцаа таагүй уур амьсгалтай болжээ. Энэ нь 1990 он гарсаар хоёр орны харилцаа өмнөх үзэл сурталжсан харилцаанаас бодит харилцаанд шилжих шилжилтийн үед гарсан үл ойлголцол гэж хэлж болохоор ажээ. Тухайлбал, Монгол, БНСУ-тай дипломат харилцаа тогтоож, БНАСАУ-ын цөмийн хөтөлбөртэй холбоотой асуудалд Монгол АНУ ба барууны орнуудын байр суурьтай нэгдсэнийг Умард Солонгосын тал таагүй хүлээн авсан юм. Мөн Монгол Улс Өмнөд Солонгостой түлхүү харилцах болсонд ч Умард Солонгос дуртай байгаагүй.

Эцэст нь БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүний Монголд хийсэн айлчлал, түүний дэвшүүлсэн “таган оролцуулах” бодлогыг Монгол Улс дэмжсэнд Пёнъян дургүйцсэн нь ЭСЯ-аа хаах нэг шалтаг болсон байх үндэстэй. Эдгээр үл ойлголцлууд хоёр орны харилцааны шилжилтийн үед гарч, энэ үед хоёр талын харилцаанд баримтлах бодлого аль аль талдаа бүрэн тодорхой болоогүй байсантай холбоотой гэж үзнэ. Мөн хоёр солонгосын асуудалд Монгол Улс цаашид нэлээд болгоомжтой хандах, тодорхой байр суурь баримтлахын чухлыг харуулсан үйл явдал болсон гэж үзэж болох юм.

Гэхдээ БНАСАУ Элчин сайдын яамаа хаасан хамгийн гол шалтгаан нь тус оронд үүссэн эдийн засгийн хүндрэл байсан гэж үзэх нь үнэнд нийцнэ. Үүнийг тус улсын ГХ-ийн дэд сайд Ким Ён Ир 2004 оны 8-р сарын 6-9-ны хооронд Улаанбаатарт айлчилж, ЭСЯ-аа нээх үеэрээ: “1999 онд Улаанбаатар дахь Элчин сайдын яамаа санхүү, эдийн засгийн шалтгаанаар хаасан. Харин өнөөдөр дахин сэргээн нээж байна” гэж хэлсэн үгнээс нь батлагдана.²² Монгол Улс ч эхнээсээ БНАСАУ Монгол дахь Элчин сайдын яамаа эдийн засгийн шалтгаанаар хаасан гэж үзэж байсныг ГХ-ны сайд Н.Туяа БНСУ-ын сэтгүүлчийн асуултад хариулахдаа дурьджээ.²³

²¹ Мөн тэнд. Хн: 210. Тал.88

²² Өдрийн сонин. 1999.05.13

²³ “Korea Times”.2000.03.1

ДҮГНЭЛТ

Хэдийгээр Умард Солонгос Монгол дахь ЭСЯ-аа хааснаар хоёр орны дипломат харилцаа хөндөгдөөгүй ч хоёр орны 50 жилийн дипломат харилцааны түүхэнд гарсан таагүй үйл явдал болсон ба БНАСАУ Монгол Улсад төлөөлөлгүй болсноор хоёр орны харилцааг идэвхтэй явуулах боломж тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан.

БНАСАУ Монгол дахь ЭСЯ-аа хаасан асуудал нь хэдийгээр тус улс манай улсын явуулсан зарим нэгэн бодлогод дургүйцлээ илэрхийлсэн мэт байсан ч гол нь санхүү, эдийн засгийн шалтгаантай байсан нь тодорхой байна. Мөн уламжлалт сайн харилцаатай, нэг бүс нутагт оршдог Монгол Улс дахь ЭСЯ хаасан БНАСАУ-ын энэхүү алхам нь тийм ч оновчтой шийдвэр байгаагүйн баталгаа нь 5 жилийн дараа ЭСЯ-аа дахин нээсэн явдал байсан юм. Харин Монгол Улс хэдийгээр санхүүгийн алдагдалтай ч БНАСАУ дахь Элчин сайдын яамаа хадгалж үлдэхээр шийдвэрлэсэн нь хоёр орны харилцааг дордуулахгүй хэвээр хадгалж үлдэх, цаашид сэргээхэд маш чухал ач холбогдолтой алхам болжээ.

НОМ ЗҮЙ

1. МУ-ын Үндсэн Хууль.1992 I.10.1 (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №1(7). 1992.1,2-р сар. Тал.3)
2. МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал 1994. I.3., II.9. (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9(28). 1994.09.01. Тал.805-807)
3. МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал 1994. I.2. (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9(28). 1994.09.01. Тал.806)
4. МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал 1994. II.12.2,3,5 (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9(28). 1994.09.01. Тал.807, 808)
5. 조선중앙년감. (Чосон төв товхимол) 1981, pp. 66-67
6. БНАСАУ-ын Үндсэн хууль 1992. I.17
7. 한국정치연구회, “북한정치론”. 서울:백산서당,(Солонгосын улс төрийн шинжлэлийн хүрээлэн, “Умард Солонгосын улс төрийн онол”. Сөүл: Бэк Сан Со Дан)1990, р.400
8. 김계동.북한의 외교정책과 대외관계. (Ким Гие Дун. Умард Солонгосын гадаад бодлого ба гадаад харилцаа) 2012. р. 79
9. Д.Уламбаяр. БНСУ-МУ-ын “гуравдагч сайн хөрш,” чухаг түнш мөн. Монгол Солонгосын харилцаа хамтын ажиллгааны тулгамдсан асуудал хэтийн төлөв. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. 2010. Тал.74 (Монгол Солонгосын харилцаа хамтын ажиллагааны тулгамдсан асуудал хэтийн төлөв. Эрдэм шинжилгээний бага хурлын материал. 2010.)
10. John Lewis Gaddis, “The Long Peace: Elements of Stability in the Postwar International System,” in Sean M, Lynn-Jones, ed. The Cold War and After: Prospects for Peace,(Cambridge, Massachusetts: The MIT Press,1991), p.17
11. Панин.А. Северная Корея. Эпоха Ким Чен Ира на закате. 2004. стр. 245
12. (“평양방송”(Пхеньян радио нэвтрүүлэг) 1998.9.13,10.3,11.13, 로동신문-근로자 공동논설”, “자립적 민족경제 건설노선 견지”),(Нодон шинмүн) 1998.9.17김계동.북한의 외교정책과 대외관계. 2012. р.205)
13. Гадаад харилцаа. Товхимол. 1999.6.4 №13. Тал.5
14. ГХЯ-ны архив. Хн:211. Тал.58-60
15. ГХЯ-ны архив. Хн:208. Тал.6,7
16. ГХЯ-ны архив. Хн:211. Тал.68
17. ГХЯ-ны архив. Хн:198. Тал.59
18. ГХЯ-ны архив. Хн:198. Тал.66
19. Г.Толорая. Корейская политика России: Попытка схематизации. Журнал “Проблема дальнего Востока” 1999.10
20. ГХЯ-ны архив. Хн: 210. Тал.88
21. Өдрийн сонин. 1999.05.13
22. “Korea Times”. 2000.03.10. Монгол улс, БНСУ-ын харилцаа 100 жил. 2000. Тал. 246
23. С.О.Курбанов. История Кореи. С древности до начала XXI в. 2009

24. БНАСАУ-ын 50 жилийн ойгоор БНАСАУ-д суугаа МУ-ын элчин сайд Д.Бямбаагийн хэлсэн үг. 1998.10.13
25. Д.Уламбаяр. Монгол-БНАСАУ-ын харилцаа. Өнгөрсөн ба одоо. Стратеги судлал сэтгүүл. 2001/1-2
26. МУ-ын Гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм 1911-2011
27. ГХЯ-ны архив. Хн:195. МУ БНАСАУ-ын ЭЗШУТ хамтын ажиллагааны ЗГ хоорондын Зөвлөлдөх Комиссын III хурлын материалаас.
28. Торкунов А. Корейский вопрос // Международная жизнь. № 5. 2003. С. 64–65.
29. А.Ланьков. Северная Корея, Попытка контр-реформ, часть I.
30. <https://ru.wikipedia.org/>